

**ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ СЭЛБЭГИЙН
ХУДАЛДАН АВАЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН**

2021 оны 02 дугаар сарын 08

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 01/21 дүгээр удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор П.Цогбаяр, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут, Д.Булган, С.Одгэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны худалдан авалт, сэлбэгийн зарцуулалтын үйл ажиллагааг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгаж, холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

ГТҮШХА нь 2020 онд 734.0 сая төгрөгийн сэлбэгийн худалдан авалт хийснээс 244.7 сая төгрөгийн худалдан авалтыг тендер шалгаруулалтын аргаар, 121.3 сая төгрөгийн худалдан авалтыг гадаадын нийлүүлэгч байгууллагаас, 58.4 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын арга хэрэглэн гэрээ байгуулах аргаар, 309.7 сая төгрөгийн худалдан авалтыг шууд худалдан авах аргаар хийсэн байна.

ГТҮШХА-ны 2020 онд худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгосон зөрчил илэрсэн.

ГТҮШХА-ны Удирдлагын баримт бичиг, Санхүү бүртгэлийн үйл ажиллагааны зааварт тус албаны худалдан авах ажиллагааг хэн, хэрхэн зохион байгуулах талаар тодорхой тусгагдаагүй байгаа нь худалдан авах ажиллагааг хариуцан гүйцэтгэх, оролцох ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхойгүй байдалд хүргэсэн байна.

Тус албаны худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, дүгнэх ажлыг ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод тодорхой зааж өгөөгүйгээс ажилтнуудын ажил үүргийн хуваарь тодорхой бус, хэн хэрхэн гүйцэтгэх, хяналт тавих нь тодорхойгүй явж ирсэн байна.

ГТҮШХА-ны жил бүрийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах ажилтан тодорхойгүйгээс тус албаны худалдан авах ажиллагааг Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу төлөвлөж, тайлагнаагүй байна.

Тус албаны тоо бүртгэлийн ажилтнууд автомашин механизмын гүйлтийг спидометрийн заалтыг үндэслэн бичдэггүй, албаны удирдлагын зүгээс автомашин механизмын спидометрийн эвдрэл гэмтлийн шалтгааныг тогтоож холбогдох ажилтнуудтай хариуцлага тооцдоггүйтэй холбоотойгоор автомашин механизмын гүйлт үнэн зөв хөтлөгддөггүй байна.

ИНЕГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр баталсан ГТҮШХА-ны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайланд нийт 19 зөвлөмж өгснөөс Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах, батлагдсан

төсөвт өртгийг үндэслэн картаар шатахуун худалдан авах ажиллагааны журмыг зөв сонгож хуулийн дагуу худалдан авалт хийх гэсэн зөвлөмжүүд хэрэгжээгүй байна.

Худалдан авах сэлбэг, бараа материалын үнийн харьцуулалтыг хэн хэрхэн хийх талаар тус албаны удирдлагын баримт бичиг, болон үйл ажиллагааны заавар, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод тодорхой зааж өгөөгүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар тус албанд 9 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА